

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**МИНЖИТ БУЛГАН ТАВАН ЦАГИРАГ СПОРТ ЦОГЦОЛБОРЫН 2020 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/135/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Ховд хот
2021 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn

Гэрээт аудитор: Б.Бадамцэцэг

Утас: 70432545

цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ЗДТГ</i>	<i>Засаг даргын дамгын газар</i>
<i>ОНХС</i>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	төгрөгөөр5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	төгрөгөөр6
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	төгрөгөөр7
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	9
Төгрөгөөр.....	9
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	төгрөгөөр.....9
3.АУДИТЫН ТАЙЛАН	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.7. Шилэн дансны мэдээлэл	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	13
Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	13
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	14
1. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал.....	14
Илрүүлэлт: Тухайн байгууллагын нягтлан бодогч нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж батлуулаагүй зөрчил дутагдал илэрлээ.....	14
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	15

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021.02.25 № 2/134
тандай _____ -ны № _____ -т

БУЛГАН СУМЫН МИНЖИТ БУЛГАН
ТАВАН ЦАГИРАГ СПОРТ ЦОГЦОЛБОРЫН
ДАРГА У.УЛАМБАЯР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Булган сумын Минжит булган таван цагираг спорт цогцолборын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын минжит булган таван цагираг спорт цогцолборын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, иргэд хүүхэд залуучуудын бие бялдар, чийрэгжилтийг дээшлүүлэх, нийгмийн эрүүл мэндийг дэмжих, спортын төрлүүдийг орон нутагт бүсийн хэмжээнд хөгжүүлэх үйлчилгээний чанар үр өгөөжийг дээшлүүлж зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


021020647

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	<u>5,669,996.54</u>
33	АВЛАГА	-	211,116.54
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	211,116.54
35	БАРАА МАТЕРИАЛ	-	5,458,880.00
354	Хангамжийн материал	-	5,458,880.00
35440	Түлш, шатах тослох материал	-	5,458,880.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	<u>3,677,000,514.22</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	3,677,000,514.22
392	Биет хөрөнгө	-	3,676,010,930.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	3,692,972,340.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(104,303,908.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	22,560,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,765,000.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	67,510,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(9,156,500.04)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	11,430,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,236,000.08)
393	Биет бус хөрөнгө	-	989,583.30
39301	Програм хангамж	-	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(260,416.70)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	=	<u>3,682,670,510.76</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>207,607.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	207,607.00
413	Өглөг	-	207,607.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	207,607.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	3,682,462,903.76
51	Засгийн газрын хувь оролцоо	-	3,682,462,903.76
512	Хуримтлагдсан үр дүн	-	3,682,462,903.76
51220	Тайлант үеийн үр дүн	-	3,682,462,903.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	=	3,682,670,510.76

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	3,869,345,240.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	3,805,313,140.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	3,805,313,140.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	3,805,313,140.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		9,590,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	3,795,722,340.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	-	64,032,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	64,032,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		64,032,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	186,882,336.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	186,882,336.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	186,779,457.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	40,146,617.47
210101	Үндсэн цалин	-	40,146,617.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	5,279,682.46
210201	Тэтгэврийн даатгал	-	3,590,962.65
210202	Тэтгэмжийн даатгал	-	422,466.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	337,972.96
210204	Ажилгүйдлийн даатгал	-	83,348.28
210205	Эрүүл мэндийн даатгал	-	844,932.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	20,655,832.00
210301	Гэрэл, цахилгаан	-	4,131,712.00
210302	Түлш, халаалт	-	14,470,120.00
210303	Цэвэр, бохир ус	-	2,054,000.00

2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,514,400.00
210401	Бичиг хэрэг	-	525,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	229,400.00
2105	Нормативт зардал	-	150,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	311,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	149,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	162,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	118,721,825.78
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	118,721,825.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	102,878.53
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	102,878.53
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	102,878.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	3,682,462,903.76
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	3,682,462,903.76

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	73,622,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	9,590,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	9,590,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	9,590,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	9,590,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	64,032,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	64,032,100.00

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		64,032,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	73,622,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	73,622,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	73,520,021.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	40,025,509.47
210101	Үндсэн цалин	-	35,805,388.10
210102	Нэмэгдэл	-	4,220,121.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	5,404,300.00
210201	Тэтгэврийн даатгал	-	3,803,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	400,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	320,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	80,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	800,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	26,394,712.00
210301	Гэрэл, цахилгаан	-	4,499,112.00
210302	Түлш, халаалт	-	19,495,600.00
210303	Цэвэр, бохир ус	-	2,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,240,000.00
210401	Бичиг хэрэг	-	230,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	250,000.00
2105	Нормативт зардал	-	150,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	305,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	215,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	90,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	102,878.53
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	102,878.53
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	102,878.53

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D08	Тайлант үеийн үр дүн	3,682,462,903.76	3,682,462,903.76
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,682,462,903.76	3,682,462,903.76

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	76786500.00	73520021.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	76786500.00	73520021.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	76786500.00	73520021.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40032200.00	40025509.47
210101	Үндсэн цалин	36650200.00	35805388.10
210102	Нэмэгдэл	3382000.00	4220121.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5404300.00	5404300.00
210201	Тэтгэврийн даатгал	3803000.00	3803100.00
210202	Тэтгэмжийн даатгал	400300.00	400300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	320200.00	320300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	80000.00	80100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	800800.00	800500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29400000.00	26394712.00
210301	Гэрэл, цахилгаан	4500000.00	4499112.00
210302	Түлш, халаалт	22500000.00	19495600.00
210303	Цэвэр, бохир ус	2400000.00	2400000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	990000.00	1240000.00
210401	Бичиг хэрэг	230000.00	230000.00
210402	Тээвэр, шатахуун	600000.00	600000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	160,000.00	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	250,000.00
2105	Нормативт зардал	150,000.00	150,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	150,000.00	150,000.00
2107	Томилолт, зочны зардал	320,000.00	-
210702	Дотоод албан томилолт	320,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	490,000.00	305,500.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	400,000.00	215,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	90,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	77,036,500.00	73520021.47
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	67,036,500.00	63 929 221.47
131001	Улсын төсвөөс санхүүжих	67,036,500.00	63 929 221.47
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,000,000.00	9,590,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	9,590,800.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6.00	6.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	1.00	1.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00
620004	Гэрээт ажилтан	2.00	2.00

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Минжит Булган таван цагираг спорт цогцолборын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга У.Уламбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч анхан шатны баримт бүрдүүлэлт, НББББ-ийн болон талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 26-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Б.Бадамцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Булган спорт цогцолборын үйл ажиллагааны эрхэм зорилго нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, иргэд хүүхэд залуучуудын бие бялдар, чийрэгжилтийг дээшлүүлэх, нийгмийн эрүүл мэндийг дэмжих, спортын төрлүүдийг орон нутагт бүсийн хэмжээнд хөгжүүлэх зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нутаг дэвсгэртээ нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх
- Иргэд, хүүхэд залуучуудын бие бялдар, чийрэгжилтийг дээшлүүлэх
- Аймгийн болон бүсийн тэмцээнд оролцох баг тамирчдыг бэлтгэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт

- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Булган спорт цогцолборын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

2020 онд тус байгууллагад дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй бөгөөд сумын төрийн сангаас өдөр тутмын гүйлгээнд хяналт хэрэгжүүлсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 3869345.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 38693.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 3869345.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 38693.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Минжит булган спорт цогцолборын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 3677000.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд шинээр үүсэн байгуулагдсантай холбоотой байна. Иймээс бүх балансын дансууд материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага		211,1	211.1
Бараа материал		5,458.9	5,458.9
Үндсэн хөрөнгө		3,677,000,5	3,677.000,5
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		3,682,670,5	3,682,670,5
Богино хугацаат өр төлбөр		207,6	207.6
Цэвэр хөрөнгө, өмч		3,682,462,9	3,682,462,9
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,682,670,5	3,682,670,5

Авлага дансны үлдэгдэл 211.1 мянган төгрөг болж өссөн нь тайлант онд Нийгмийн даатгалын шимтгэлийг тооцоо нийлж баталгаажуулаагүйтэй холбоотой авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5458.8 мянган төгрөг болж 5458.8 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд нүүрс нөөцөлсөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эцэст Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ны 212 тоот тогтоолоор 3795722.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн данс нь тайлант оны элэгдлийн зардал 118721,8 мянган төгрөг байгаатай холбоотойгоор буурсан байна.

Өр төлбөр оны эцэст 207.6 мянган төгрөг болж өссөн нь тайлант онд ХХОАТ-ыг дутуу төлсөнтэй холбоотой байна.

Булган спорт цогцолборын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 3869345,2 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд 64032,1 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлого 9590.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй орлого 3795722.4 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардлаа тайлант онд 186882.3 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 77036.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 77036.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2019 оны 12 дүгээр сарын 18/06 тоот тогтоолоор Булган спорт цогцолборын 2020 оны төсвийг 77036.5 мянган төгрөгөөр баталжээ.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 77036.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 67036.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 10000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 64032.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 9590.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж нийт 73622.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 73520.0 мянган төгрөгийг зарцуулж 102.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 73520.0 мянган төгрөг буюу 95,4 хувьтай байгаа нь гэрэл цахилгааны зардлыг 0,8 мянган төгрөгөөр, цалингийн зардлыг 6,7 мянган төгрөгөөр бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 95,3 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээ 102.8 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой томилолтын зардал зарцуулах эрхийг нээж өгөөгүйтэй холбоотой хэмнэлт гарсан байна.

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	102.0
80109	Тогтмол зардал	0.8
	ДҮН	102.8

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллийг оруулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шинээр байгуулагдсан тул санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2161.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1350.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулагдаагүй 2515.2 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 1350.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 811.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний болон үр дүнгийн орлогыг 1350.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулж 1350.0 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэх асуудал байхгүй болно.

Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар анхаарал татах асуудал байхгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд худалдан авсан бараа бүтээгдэхүүн, нүүрс, шатахууны гарсан зардлуудыг баримтжуулахдаа И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгох, шатахууны тайлан гаргаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, замын хуудас бичээгүй, даргын зөвшөөрлийн бичгээр олгодог 600.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

1.2 Эрсдэл: Төсвийн зарцуулалтын хяналт сулрах, харилцагч байгууллага татвараас зайлсхийх

1.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2.1 Балансын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд зөрүүтэй тайлагнасанатай холбоотой нийгмийн даатгал, ашгийн татварын 211.1 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

2.2 Эрсдэл: Зардлыг нотлохгүй байх, төсвийн үргүй зардал нэмэгдэх

2.3 Өгсөн зөвлөмж : Энэ нь Иж бүрэн, Хэмжилт, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, 20-р зүйлийн 20.2.5 дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, Төсвийн тухай хуулийн 41.2.3. төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах гэсэн заалтуудыг хэрэгжүүлж, тооцоо нийлэх

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг.

Илрүүлэлт: Тухайн байгууллагын нягтлан бодогч нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж батлуулаагүй зөрчил дутагдал илэрлээ.

Дээрхи алдаа зөрчил нь НББ-ийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.2. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана. *гэсэнтэй нийцэхгүй байна.*

Эрсдэл: Төсвийн тайланг зөв илэрхийлэх бодлого алдагдах

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцсэн нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг боловсруулж, батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Булган спорт цогцолборын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/135/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Булган спорт цогцолбор		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Мөнгөн болон үр дүнгийн тайлангийн үндсэн үйл ажиллагааны орлогыг зөрүүтэй тайлагнасан	1350.0	Залруулга хийх		
2	Тайлант онд худалдан авсан бараа бүтээгдэхүүн, нүүрс, шатахууны гарсан зардлуудыг баримтжуулахдаа И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгох, шатахууны тайлан гаргаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, замын хуудас бичээгүй, даргын зөвшөөрлийн бичгээр олгодог 600.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.	600.0	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	У.Уламбаяр Г.Оргил
3	Авллага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд зөрүүтэй тайлагнасантай	211.1	Зөвлөмж өгөх		
4	НБББББ-ийг боловсруулан мөрдөөгүй.	0	Зөвлөмж өгөх		
ДҮН		2161.1			

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН

ГЭРЭЭТ АУДИТОР:

Б.БАДАМЦЭЦЭГ